

## Эрдэм шинжилгээний хуралд тавих илтгэл

1. Оршил хэсэг: – Ховдын хязгаарын түүхэн товчоо нь
  - Торгууд , Захчин хошууны түүхэн товчоо
2. Үндсэн хэсэг: – Оспаны халдлага довтолгоонд баруун хилийн ард иргэд өртсөн нь:
  - Манай төр засгаас явуулсан бодлого, Оспантай хийсэн уулзалт үр дүн
  - Маршил Х.Чойбалсангийн өгсөн үүргийн дагуу хилчдэд туслах ардын сайн ардын сайн дурын групп байгуулсан нь.
  - Алтай, Үенч сумын ард иргэдийн оролцоо
  - Группийн гишүүдийн гүйцэтгэсэн үүрэг ололт амжилт
3. Төгсгөл хэсэг: - Товч дүгнэлт, авах арга хэмжээ

### **ХОВДЫН ХЯЗГААРЫН ТҮҮХЭН ТОВЧОО НЬ**

Монгол улсын өмнөд хил нь 1695-1850 онд орон нутгийн хэмжээнд Ар, Өвөр Монголын эртний аймаг, хошуудын бэлчээр нутгийн хуваариас үүсгэн тогтоогдож, овоо тэмдгүүдээр тэмдэглэгдэн тогтоогдсон түүхтэй. Манж Чин улсын ноёрхлыг эсэргүүцсэн бослого, хөдөлгөөнүүд ХХ зууны эхээр Хятад, Монгол улсад өрнөж, Халхын ноёдын төлөөлөгчид Хаант Орос улсаас дэмжлэг авч, Манжийн захиргааг халж, 1911 оны 12 дугаар сарын 29-нд тусгаар тогтнолоо зарлаж, Богд Жавзандамбыг хаан ширээнд өргөмжлөн улсын нэрийг Монгол хэмээн төрт ёсоо дахин сэргээв. Богд хаант Монгол улсын засгийн газар хойд зүгийн зах хязгаарыг хамгаалж ирсэн эртний өрхийн гэр болон суман харуулуудыг өөрчлөн зохион байгуулж, Хаант Орос Монгол улсын хилийг өрхийн харуулуудаар хамгаалуулах болжээ. Харуулууд нь улсын хил хамгаалахын зэрэгцээ сүм, дуган шүтээний бүрэн бүтэн байдлыг давхар хариуцдаг байв. Богд хаант Монгол улсын засгийн газрын бодлого нь Манж, Хятадын дарлалаас Өвөрмонгол, Баргын газар нутгийг салган авч өөртөө нэгтгэн Монгол үндэстний хүчирхэг төр улсыг байгуулах улс төрийн сонирхолтой байлаа. Гэвч тэр үеийн Орос, Хятадын засгийн газрын бодлогоос шалтгаалан хүчин мөхсөдөж дээрх зорилгодоо хүрч чадаагүйгээр барахгүй газар нутгаа алдсан юм. 1913 оны 10-р сард Орос Хятад хоёр улсын Бээжинд байгуулсан тунхаглалаар Алтайн хязгаарт Хятад улс, Тагна Тувагийн хязгаарыг Хаант Орос тус тус авахаар хэлэлцэн тохирсон байна. 1913 онд Хятадын засгийн газар Алтайн хязгаарыг хүчээр нэгтгэн авахаар үлэмж цэргийг Монголд түлхэн оруулж, зарим газрыг эзлэн авснаар Монгол, Хятадын хооронд зэвсэгт мөргөлдөөн эхэлжээ. 1913 оны 12-р сард Монголын талыг Шар сүмд байсан Оросын консул М.Н.Кузьминский, Хятадын талыг Торгуудын ван Балт нар төлөөлөн байлдааны ажиллагааг зогсоох хэлэлцээр байгуулж, Алтайн нуруугаар Цагаан түнгэ хүртэл цэрэггүй бүс тогтоожээ. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Хаант Орос, Хятад хоёр Алтайн нуруугаар цэрэггүй бүсийн шугамыг улсын хил хэмээн Монголд хүчээр тулган хүлээлгэж, 1914 онд Тагнын Тува, Хаант оросын эзэмшил болсныг баталсан байна. Ингэж Алтайн

нурууны өмнөд бэл, Хар эрчис, Чингил, Булган, Өрөнгө голууд, Өрөнгөр нуурын сав дагуух Монголын нутаг Хятадын мэдэлд оржээ. 1915 оны Монгол, Орос, Хятад гурван улсын Хиагтын гэрээгээр тогтоосон Хаант Монгол улсын нутаг дэвсгэрийн зах хязгаар одоогийн Монгол улсын гадаад хилийн үндэс болж байна. Монголчууд тусгаар тогтнолоо 1915 оны Хиагтын гэрээгээр устгуулж, 1919 онд Хятадын цэргийн эрхтнүүдэд эзлэгдэж үндэсний хөдөлгөөнүүд өрнөн 1921 онд хувьсгал хийн ялснаар XX зууны Монголын түүхэнд шинэ үе эхэлж, тус оронд нийгэм эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлтүүд хийгдэх болов. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын түүхэн гавьяа нь дэлхийн олон улсын тавцанд тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол улсыг дахин гарган улсын хил хязгаар, газар нутаг, ард түмний уламжлалт зан заншил, соёлыг баттай авч хадгалан үлдээсэнд оршино.

### ***Торгуудын түүхэн товчоо***

Торгуудын үүсэл нь XIII зуунаас эхтэй гэж болно. Учир нь Чингис хааны шадар хишигтэн цэргийн дотор турхаг хэмээх цэргүүд байсан нь Торгуудын өвөг дээдэс болсон байх талтай. 1368 онд Юань улс мөхсөний дараа Монголчууд хоорондоо ширүүн тэмцэлдэх болов. Энэ тэмцлийн үеэр XV зууны үед Хэрэйдийн Амгалан тайш харьяат албатаа авч, Ойрадын Тогоон тайшид дагаар оров. Энэ үеэс хойш Торгууд аймаг Ойрадын нэгэн хэсэг болсон юм. Торгуудын зарим хэсэг Дөрвөд, Хошуудын хамт Ижил мөрөнд очиж Халимагийн хаант улсыг байгуулж байв. Торгуудын үлдсэн хэсэг нь Зүүнгарын хаант улсын захиргаанд орсон ба бас зарим хэсэг нь Хөх нуур, Эзний голд оршин сууж байв. Торгуудууд одоо үед ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улс, БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө засах орон, Ганьсу муж, Монголын Ховд аймагт оршин суудаг.

### ***Захчин хошууны түүхийн товчоо***

Захчинууд Манхан, Мөст, Зэрэг, Үенч, Алтай суманд бөөнөөрөө оршин сууж байна. Судлаачдын үзэж байгаагаар захчин нь харьцангуй хожуу буюу XVII зууны эцэс XVII зууны эхэн үед бүрэлдсэн аж. Анх 1760-аад оны үед Зүүн гарын Галдан бошгот хаан Ойрадын тайж нарын эзэмшил “анги” бүрээс цөөн албат өрхийг татан улсынхаа зүүн өмнөд Эрээн хавиргын газар хил харгалзуулан суулгажээ. Тийнхүү Зүүн гарын хаант улсын хил хязгаарыг сахигч харуулын ардыг “захчин” гэж нэрлэснээр, захчин хэмээх угсаатны бүлэг түүхийн тавцанд гарч ирсэн. Захчинууд 1754 онд Манжид эзлэгдэж Халхын засагт хан аймгийн гүн Цэвдэнжавын харьяанд хэсэг зуур захирагдаж явсан. Тэднийг Зайлганы газар түр суулгаж байгаад 1756 онд Зэрэг, Шар хулс зэрэг газар нутаглуулжээ. Улмаар 1759 онд тэдэнд нутаг олгож Байдаг, Хавтаг хавьд нутаглуулсан байна. Гэвч удалгүй газрын ойрыг харгалзаж, 1777 оноос захчиныг Ховдын манж сайдын мэдэлд захиргасан байна. 1801 онд Ховд хот, Өрөмчийн манж сайд нар зөвлөлдөөд Ховд, Гүйчэн хотын хооронд тавьсан, суурь өртөөний албыг гүйцэтгэж байсан халхын ардуудыг татан буулгаж нутагт нь буцаагаад, оронд нь захчинаас 80 өрх цэрэг гарган өртөөний албыг хаалгасан нь манжийн дарангуйллын

туршид үргэлжилжээ. 1911 онд Монголчууд манжийн ноёрхлыг түлхэн унагасны эсэргэн жил буюу 1912 онд монголын засгийн газраас манжийн тогтоосон хуучин засаг захиргааг устгахад захчин хоёр хошуу Дөрвөдийн үнэн зоригт ханы аймагт захирагджээ. Мөн захчины хоёр хошууны ноёдод манжаас олгосон хошуу захирах тамгыг хүчингүй болгож, шинэ тамга олгон бүгдийн даргыг үе улиран залгамжлах хошуу ноён болгож, гүнгийн хэргэм шагнажээ. Тэр үеэс захчины хойд хошууг захчин сэцэн гүнгийн хошуу, урд хошууг захчин бэйлийн хошуу хэмээн нэрийдэх болов. 1925 онд ардын засгийн газрын шийдвэрээр захчины хоёр хошууг нэгтгэн Баатархайрхан уулын хошуу хэмээн нэрлээд, Улаангомд төвлөсөн Чандмань уулын аймагт захируулжээ. Гэвч 1931 онд хуучин Захчин бэйлийн хошуугаар Үенч, Захчингүнгийн хошуугаар Манхан, Зэрэг, Мөст, Алтай сумдыг байгуулж Ховд аймагт захируулав. Эл зохион байгуулалт өдгөө ч өөрчлөгдөөгүй хэвээр байна.<sup>1</sup>

## **ОСПАНЫ ХАЛДЛАГА ДОВТОЛГООНД БАРУУН ХИЛИЙН АРД ИРГЭД ӨРТСӨН НЬ**

Өнгөрсөн зууны гучаад оны эхээр Шинжаан мужид өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь БНАМУ-ын алс баруун хязгаарын ард олны амар амгалан аж төрөх хийгээд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдалд сөргөөр нөлөөлсөн байна. Гоминданы цэргийн генералууд, ялангуяа Ганьсу мужийн милитарист Японы талыг баримтлагчид, хэзээнээс бие даасан байдалтай оршиж ирсэн Шинжаан мужийг бүрэн эзэлж, улмаар Монголын олон ястны өлгий нутаг баруун хязгаарыг таслан авахаар улайрч байлаа. Гэлээ ч Шинжаан мужид олон жил үргэлжилсэн эрх чөлөөний хөдөлгөөн туйлдаа хүрч, Гоминданы цэргийн эрхтнүүд, ноёд, баячуудын дарлал мөлжлөгийн эсрэг чантуу, торгууд, хасаг, урианхай, хятад зэрэг үндэстэн ястнууд зэвсэгт тэмцэлд нэгдэн, боссоноор 1938 оны дөрөвдүгээр сарын 12-нд Өрөмч хотод ардчилсан хувьсгалт засаг тогтсон юм. Гоминданыхан санаархлаа орхисонгүй, зорьсондоо хүрэхийн тулд хувьсгалыг нухчин дарах, дээрмийн амьдралыг эрхэмлэн шүтдэг хасгуудыг БНАМУ-ын эсрэг үймээн самуунд ашиглахыг оролдож байжээ. Мөн эрх ямбаа алдсан том феодалууд нутгийн айл өрхийг ятган Шинжаанд шинээр тогтсон хувьсгалт засгийн эсрэг 1940 оны гуравдугаар сард зэвсэгт бослого гарган бут цохигдон, сарнин бутарсан эрээвэр хураавар хэсэг нь ууланд бүгэн ойр хавийнхаа нутагт дээрэм хийж амьдрах болов. Дээрэмчид манай хилийн сумдын малчдын мал хөрөнгийг тонон дээрэмдэх, энгийн хүмүүсийг алж хядах нь хэтрэв. Зөвхөн 1934 оны долоогоос 12 дугаар сар хүртэлх хугацаанд Алтайн хилийн камендатурын хариуцсан хэсгээр дээрэмчдийн зэвсэгт халдлага Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Мөнххайрхан, Манхан, Цэцэг сумдын нутгийн хамарч, 606 өрх айлыг дээрэмдэн, 19 хүний амь насыг бүрэлгэж, 11 хүнийг шархдуулан, 5 охиныг олзлон аваачсан байна.<sup>2</sup> Хятадын төр Засгийн газраас гадаад Монгол нь тус улсын нэг муж гэж үзэн, манай улсын баруун хязгаарын дагуу цэргийн анги, салбараа татан төвлөрүүлж, “Монголын хилд халдан

<sup>1</sup> А.Бямбасүрэн:Орон нутгийн мэдээ /Ховд/ 2017он 01сар 09

<sup>2</sup> “БНАМУ-ын Хязгаарын Цэргийн түүхэн замнал.УБ.1972

довтлох ажилдаа тус улсаас дүрвэн гарсан иргэдийг ашиглан, тэдний дээрэм тонуулын үйл ажиллагаанд нь бүхий л хэлбэрээр туслан дэмжиж, хил орчмын оршин суугчдыг нутгийн гүн рүү дүрвүүлэн нүүлгэж, эзгүйрсэн орон нутагт өөрсдөө бэхжин суух бодлогыг баримталж байв<sup>3</sup>

- 1930-аад оноос эхлэн Оспаны хасаг өрх айлууд /60-70 өрх айл байсан гэдэг/ Монгол, Хятадын хилийн завсар байрлаж, хоёр талдаа дээрэм тонуул хийдэг байжээ. 1933 оны зун гэхэд Чингэл, Цагаанголд 600 хүн, Эрчис голын эхэнд 300, Байтаг, Хавтаг уулын орчим 700 гаруй гаруй хүнтэй зэвсэгт бүлгүүд суурьшин Монгол улсын нутгийн гүнд 200 км хүртэл нэвтэрч, Дээрэм аллага үйлдэж байсан ба 1934 онд 500 орчим Хуйхуу цэргийн хүчээр Монголд довтлон Алтай давааны өвөр хэсгийн эзлэх төлөвлөгөөтэй байжээ.

- Ховдын ард иргэд дайны хөлд нэрвэгдсэн талаар: 1934 оны 8 дугаар сарын сүүлээр Ховд аймгийн орлогч дарга Нуушаа дайн дажны хөлд Ард иргэд хэрхэн нэрвэгдсэн тухай: "Булган сумаас 142 өрх, Алтай сумаас 114 өрх, Үенч сумаас 98 өрх, Мөнххайрхан сумаас 97 өрх, Манхан сумаас 45 өрх, Улаанхус сумаас 10 өрх айлууд харийн түрэмгийлэгчдэд тонон дээрэмдүүлж ноцтой хэлмэгдлээ, Тэдний 120 өрх нь гуйланчлахаас өөр аргагүй боллоо. Энд 30 хүн тамлагдан алагдаж, 8 хүн шархдаж, 9 хүн олзлогдож, 48772 толгой Бог, 8885 толгой бод малаа дээрэмдүүлж, олон гэр, Байшин, Баян бүрд, Нуга, Хөндий хадлан Өтөг, Бууц шатаан сүйтгэлээ" гэж илтгэж байжээ. <sup>4</sup>

- Ингэснээр нүүдэлчин хасгийн омгууд баруун хилийн дагуух газарт бөөнөөр ирж суурьших болжээ. Энэ үед гоминданыханд баривчлагдсан лалын шашны лам, ноёдоо суллахын төлөө тэмцэх нэрээр байр сууриа бэхжүүлсэн Оспаны нөлөө тэлж, дээрмийн ажиллагаа нь улам идэвхжив. Хятадын цэргийн эрхтнүүд ч энэ байдлыг овжиноор ашиглан Оспаныг Монголын хилийг нэвтрэн дээрэм тонуул хийхийг хатган турхирч байлаа. Тухайлбал, "1942 оны зургаадугаар сарын 15-нд гоминданы цэргийн дарга Лю Зу-хуй барьцаанд байсан Оспаныхны гэр бүлийн хүмүүсийг өөрийн элчийн хамт явуулахдаа "Зэвсгээ хураалгаж манай талд орох хэрэгтэй. Тэгвэл та нарт ямар ч аюулгүй" гэж бичсэний хариуд Оспан "Казахын нөлөө бүхий эрх баригчдыг суллагтун. Баригдсан хүмүүсийн гэр бүлийг суллагтун! Чингэл, Булантохойг чөлөөл. Хятадын цэргийг Алтайгаас зайлуул! Хэрвээ энэ шаардлагыг биелүүлбэл бодож үзнэ. Харин буу зэвсгээ хураалгахгүй" гэсэн бичиг илгээжээ. <sup>5</sup>

- Гоминданы хятадын түрэмгий бодлогын талаар: Гоминданы хятадын түрэмгий бодлого 1944 оны үед монгол улсад дайны аюул тулгаж байсан бөгөөд энэ үед Оспаны хасгийн бүлэг оршин байх арга дуусан байлаа. Оспан Монгол Улсын Засгийн газарт удаа дараа хүсэлт тавьж газар нутаг олгох, өргөн хэрэгцээний бараа, буу зэвсэг өгөхийг хүсэж байлаа.

- Гоминданы арми "Орон нутагт өрнөсөн эрх чөлөөний тэмцэл хийгээд аюул таригч дээрэмчдийн бүлэглэлийг дарья" гэдэг нэрээр халхавчлан Булган, Чингэл

<sup>3</sup> .("Хилчин" сэтгүүл. 2018 он. №1.24 дэх тал).

<sup>4</sup> Х. Чагдаа "Хавтаг харуул- Алтайханы эх оронч хөдөлмөрч уламжлал" 2004 он 31-р тал

<sup>5</sup> (Хамтын бүтээл. "Монгол Улсын хил хамгаалалтын түүх" Дэд боть. УБ. 2008 он. 173 дахь тал)

голын бэлчирт орших Чингэл хошууны төвд явган цэргийн анги, хуягт, нисэх хүчний салбар, морин хороо, Цонж хотод томоохон нэгтгэлийг татан байрлуулав. Харин манай талын хилд “Хилийн тавдугаар отряд, түүний харьяа заставууд үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд хилээс зайдуу байрласан Ховдын 4 дүгээр морьт хорооноос өөр хил хамгаалалт, халхлалтын зориулалттай анги, салбар байсангүй<sup>6</sup>

- Хилийн цаана бөөгнөрсөн Гоминданы анги нэгтгэл, дээрэмчдийн бүлэглэлийн харьцаа манай улсын баруун хилийг хамгаалж байсан хилчдийн хүчнээс ийнхүү олон дахин давуу байжээ. Дээрэмчдийн бүлгүүд 1940 оноос эхлэн Ховд аймгийн Булган, Үенч, Баян-Өлгий аймгийн Хужирт зэрэг сумын нутгаар дээрэм хийх нь ихсэж ард иргэдийн амгалан тайван байдал алдагдаж, амьдрал ахуй өдрөөс өдөрт доройтож байгаа энэ цаг үед төр засгийн зүгээс тодорхой арга хэмжээ авчээ.

### **МАНАЙ ТӨР ЗАСГААС ЯВУУЛСАН БОДЛОГО, ОСПАНТАЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ, ҮР ДҮН**

Улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх талаар манай нам засгаас олон чухал арга хэмжээ авсны нэг нь МАХН-ын Төв Хорооноос 1942 оны наймдугаар сарын 31-нд гаргасан тогтоол юм. Энэ тогтоол нь манай хязгаарын цэргийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болсон билээ. МАХН-ын Төв Хороо Энэ тогтоолдоо тухайн үеийн олон улсын байдалд гүнзгий дүн шинжилгээ хийж, аугаа их зөвлөлтийн ард түмнээс фашист яргачдын эсрэг явуулж байгаа тэмцэл, Ялалтын дэлхий дахины ач холбогдол, фашист германтай эвсэлдэн сүлбэлдсэн японы милитаристууд, гоминданыхны түрэмгий санаархал манай орны аюулгүй байдалд байнга заналхийлж байсан нөхцөлд хязгаарын цэргийн дайчдын үүрэг зорилтыг яруу сайхан тодорхойлон зааж өгсөн юм.<sup>7</sup>

- БНМАУ-ын ерөнхий сайд Маршал Х.Чойбалсан, МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, Армийн улс төрийн газрын дарга, армийн комиссар Ю.Цэдэнбал нар улс орны аюулгүй байдлыг хангах асуудлыг гардан зохион байгуулж байсан бөгөөд тэдний шууд оролцоотойгоор гоминданы түрэмгийлэгчид оспаны дээрэмчидтэй тэмцэх тактикийн хувьд нарийн боловсруулсан төлөвлөгөө хийсэн юм. Юуны өмнө хятадын харгис цэргийн эрхтэн, оспаны дээрэмчдийн хоорондын зөрчлийг ашиглах, нэгийг нөгөөгөөр цохиулах нь манай гол зорилт байсан.<sup>8</sup>

Хязгаарын цэргийн тагнуулын хэлтсийн Ховд отряд дахь ... дугаар тасгийн лавтай тогтоосон мэдээнээс үзэхэд оспаны дээрэмчид гоминданы цэрэгт шахагдан газар нутгаар хавчигдан манай хилийн ойролцоо ууланд бүгж байлаа. Тэд гоминданы цэргийн агт морьд, эд хогшлыг удаа дараа дээрэмдэж байсан учир гоминданы хятадууд тэдэнд өршөөл үзүүлнэ гэдэгт төдийлөн итгэхгүй байв. Үүний

<sup>6</sup> Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ.1990 он.224 дэх тал

<sup>7</sup> Б. Дорж “эх орны төлөө цохилох зүрх” 81-р тал

<sup>8</sup> Б. Дорж “эх орны төлөө цохилох зүрх” 82-р тал

зэрэгцээ тэд идэх хоол өмсөх хувцас, зэр зэвс гийн нөөцгүй учраас тун ч гачигдан, цаашид хэрхэн аж төрөх, яахаа ч мэдэхгүй болохыг илрүүлэн тогтоо- сон нь маш үнэтэй чухал мэдээ байлаа. Миний бие Дотоод явдлын Яамны удирдлагаар дамжуулан маршал Х. Чойбалсан, Ю. Цэдэнбал нарт энэ тухай илтгэлээ.

- 1943 оны наймдугаар сарын дундуур засгийн газрын ордонд Маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нар Дотоод явдлын Яамны сайд Б.Шагдаржав, орлогч сайд Д.Дүйнхэржав бид гурвыг зөвлөхтэй нь хамт хүлээн авч тус улсын баруун хилийн байдал, нэн даруй авбал зохих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах асуудлыг хэлэлцлээ. Бид нам засгийн шийдвэрийг биелүүлэх анхны алхмаа Оспаныхантай холбоо тогтоож хэлэлцээ хийх ажлаас эхлэхээр шийдэв. Энэ ажлыг зохион байгуулахаар Дотоод явдлын Яамны орлогч сайд хурандаа Б.Дүйнхэржав Ховд аймгийн төвд хүрэлцэн ирэв. Нөхөр Б.Дүйнхэржав Оспаны лагерь руу хэд хэдэн удаа элч явуулсан боловч тэд хил дээр уулзаж хоёр талын хэлэлцээ хийе гэсэн манай саналд нэг л эргэлзээд байв. Гэсэн ч бид энэ саналаа уйгагүй шургуу тэвчээртэй тавьсаар байлаа. Оспантай уулзаж холбоо тогтоохын тулд олон удаа оролдсоны эцэст Оспаны лагерь руу хамгийн гол нь тэдний зан заншлыг сайн мэдэх, хашир туршлагатай ухаалаг, үнэнийг ойлгуулж чадах тийм хүнийг явуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнээс өмнө явуулж байсан элч маань зарим талаар энэ шаардлагыг бүрэн хангаж чадаагүй, зарим нь ердөө хэл болж очих төдий байсныг ойлгосон юм. Олон ч хүнийг судалж, нарийн хэлэлцэж ярилцсаны эцэст Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын малчин ард У.Хамхаашийг явуулахаар тогтов. Өвгөн хасаг У.Хамхааш бол туйлын ухаалаг, казакийн ёс заншил, сайн муу тал, хүний үгний өө анддаггүй хашир догь хүн байсан юм. Энэ ч зөв шийдвэр болж холбоо тогтоох ажил амжилттай болсон билээ

- Оспан ийнхүү манай элчийг эгүүлэн явуулахдаа дор дурдсан утга бүхий бичиг өгч явуулсан юм. Үүнд:

- Бид 1940 онд гоминданы хятадтай байлдаж Булган голд очиход монголчууд бидний өмнөөс хашиж хөөснийг бид мартаагүй байна. Хэрэв та нар үнэн сайн санаа гаргаж байгаа бол баримтаар нотол гээд эцэст нь эд бараа, нэг дуран өгөхийг хүссэн байлаа. Оспан энэ бүх эд юмсаар үнэн хэлж байгаа эсэхийг шалгах гэж боджээ. Бид Оспаны хүссэн ёсоор эд бараа, дуран, мау-зер буу хүргүүлсэнд тэр 1943 оны есдүгээр сарын 30-нд Хайртын даваан дээр уулзах тухай манай тавьсан саналыг зөвшөөрсөн хариу ирүүлэв.

- Манай тал 1943 оны аравдугаар сарын 5-ны өглөөнөөс эхлэн Хайртын давааны өндөрлөгөөс Оспаны ирэх чиглэлд хяналт хийсээр байлаа. Үдийн алдад Оспаныхан Хайртын давааны чанд зэвсэглэсэн 100 гаруй хүмүүсээ орхиж 13 цагийн орчим Оспан 40-өөд хүн дагуулан хүрч ирлээ. Тэдний дунд Оспаны шадар туслах Сумхааз, Копас. Жолдбай, орос Александр Чернеекын зэрэг хүмүүс байв.<sup>9</sup>

---

<sup>9</sup> Б. Дорж “эх орны төлөө цохилох зүрх” 86-р тал

Уулзалт төлөвлөсний дагуу амжилттай болж, Оспан ч манайхны тавьсан саналыг зөвшөөрч энэ үндсэн дээр доорх зүйлийг хэлэлцэн тохирсон юм. Үүнд:

1. Оспанчууд БНМАУ-ын эсрэг дээрмийн ажиллагаа явуулахгүй байх;
2. БНМАУ-аас эд материалын тусламж авах;
3. Оспанчууд өөрсдийн гэр бүл эд хөрөнгө, хүмүүсийнхээ хамт монгол улсын хилийн орчим нутагт суурьшин гоминданы цэргийн эсрэг тэмцлээ үргэлжлүүлэн явуулах;
4. Эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж байгаа Синьзяны ард түмний тэмцлийг дэмжихээр хэлэлцэн тохирсны үндсэн дээр Оспанчуудын гэр бүл, зарим отрядууд нь тус улсын хилийн орчим нутагт ирж суурьших болсон юм.

Оспаны итгэлийг олохын тулд генерал Б.Дорж Булган голын шугуйд, маршал Х. Чойбалсан анх Алагтолгойд, сүүлд 1944 оны 3 дугаар сарын 5-нд Булган голын Майхан толгойд гэрт нь очиж уулзан ярилцсан байдаг. Эдгээр уулзалтын үр дүнд 1943-1946 онд буюу Оспаныг Гоминданы талд урвах хүртэлх хугацаанд дээрэмчдийн халдлага түр боловч намжсан байна. Хилийн түгшүүртэй байдал түр амсхийсэн энэ жилүүдэд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын шууд санаачилгаар Ховдын 4 дүгээр морьт хороог Булган суманд нүүлгэн суурьшуулж, хилийн суман заставуудын хүчийг нэмэгдүүлсний дээр Хэнтий аймгийн төвд байсан морьт бригадыг Ховд аймгийн Үенч сумын нутаг Улаан-Үзүүрт татан авчирч, мөн нисэх эскадрилийг Булган суманд байрлуулжээ.

### **Маршил Х.Чойбалсангийн өгсөн үүргийн дагуу хилчдэд туслах ардын сайн ардын сайн дурын групп байгуулсан нь**

Хил хамгаалалтыг сайжруулахын тулд авсан нэг чухал арга хэмжээ нь Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Баян-Өлгий аймгийн Хужирт зэрэг хилийн ойролцоо сумын ардуудыг зохион байгуулж нэгтгэн, зэвсэглэсэн явдал байв. Ардууд хил хамгаалалтын 2 дугаар заагт хил хамгаалах ажилд идэвхтэй оролцож ирсэн юм.

Маршал Х.Чойбалсан 1944 оны 2 дугаар сард баруун хилд Оспантай уулзах үеэрээ Батбаярын Дүгэрийг дуудуулан уулзахдаа хилчдэд туслах тусгай үүрэг гүйцэтгэх ардын сайн дурын группийг зохион байгуулж удирдахыг түүнд зөвлөжээ.

Маршалаас ардын сайн дурын групп байгуулах ажлыг идэвхжүүлэх үүднээс аймгийн дарга Баатаржав, Булган сумын дарга Банзрагч нартай уулзан “нөхөр Б.Дүгэр нам, засгийн даалгаврыг биелүүлж, ардын сайн дурын группийн даргаар ажиллахыг дуулгаад уг” группэд ажиллах санал өгсөн сумын нарийн бичгийн дарга Б.Чулуундай, артелийн дарга П.Раазан нарыг ажлаас нь чөлөөлж өг!” гэж үүрэг өгсөн байна. Б.Дүгэр нам, засгийн үүрэг даалгаврыг үнэнч шударгаар гүйцэтгэж чадах дотнын итгэлт 40 хүний нэрийг гаргаж маршалд танилцуулжээ.

- Генерал Доржийн үүргийн дагуу группийн гишүүдийн хурлыг 1944 оны 3 дугаар сарын сүүлчээр хийж, группийн орлогч даргаар Т.Амарзаяа, нарийн бичгийн даргаар Б.Чулуундай нарыг томилж,намын хэсгийн ахлагчаар артелийн дарга Раазанг баталжээ. Ийнхүү Б.Дүгэр генерал Доржийн шууд удирдлага дор 40-өөд гишүүдтэй группийг удирдан үүргээ нэр төртэй биелүүлж, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд амь биеэ зориулж явсан гавьяат үйлстнүүдийн нэг юм. Группийн гишүүд Гоминданы цэрэг, Оспаны дээрэмчдийн бүлэглэлийн байршил, үйл ажиллагааг тагнан турших,амьд хэл олзлох,хилчидтэй мөр зэрэгцэн дайсантай тулалдах, хүчинд автан хилийн цаана нүүж очсон өрх айлуудыг нутагт нь буцаан авчрах зэрэг олон удаагийн амь өрссөн чухал даалгаврыг гүйцэтгэж ирсэн билээ. Ардын сайн дурын группэд Төмөрцогтын Амарзаяа, Баатарын Чулуундай, Андуугийн Дүгэр, Хонгиогийн Чойрог, Батжаргалын Дүгэр, Балдайн Төмөр, Магнайн Маргаажав, Болдын Батаа, Самайн Мэндээ, Цагааны Пагваа, Шаалуугийн Хишигт, Мятавын Ширнээ, Жамбын Таазгай, Түмэнтөрийн Даш, Авирын Чулуундай, Мужиндайн Түмбээ, Гашгайн Жимбэ, Ногоодойн Магдаа, Гуналбайн Мэргэн, Баярын Рааш, Очирын Нямдэлэг, Цоохорын Пунцагдаш, Санжийн Бельбээ, Шурагийн Батжих, Соломын Мөнхдаш, Нүүдэлийн Наят, Цагааны Жамба, Рагчаагийн Зодов, Хангиагийн Бат-Өлзий, Үрэнгээн Батаа, Гашгайн Читгээ, Өлзийтийн Насан, Мөнхөөн Дандар, артелийн дарга Пагмын Раазан, Батын Нагваан нарын 40 хүн анх оржээ.<sup>10</sup>

Дараа нь дахин 60-аад хүнийг нэмж элсүүлсэн бөгөөд гол төлөв 20-45 хүртэл насны эрчүүдийг дайчлан оролцуулсан байна. Үүнд: Баясгалангийн Бадам, Энхийн Шилэг, Батмэндийн Бүрэнтөгс, Сүхравдангийн Чой, Батын Ишгэн, Бальдаан Шилэг, Баядаан Ноосой, Цэвэгжавын Халтмаа, Авирмэндийн Төртогтох, Бэхээн Дүгэр, Жаргалын Жунтаан, Насаан Дамиран, Надмидын Осор, Жэхэйн Пунцаг, Үйлдээн Дашбэлэг, Соломын Лхамаа, Манжийн Төмөржөөн, Хаймуугын Цэндээ, Таравжийн Дашдаваа, Жамбын Баяр, Гоошоон Санжмятав, Аюушийн Даш, Гомбын Аюуш, Баясгалангийн Очир, Цэрэнгийн Олцтой, Күүкын Түмбэлдэй, Гашгайн Читгээ, Доригийн Баянбаа, Раашийн Цэрэндулам, Чимэдийн Риймэд, Данжаан Аюуш, Галиндэвийн Дэнзэн, Пунцагийн Найдаа, Мягмарын Ядам, Авдарахманы Капитан, Амарзаяагын Шилэг, Ноостын Шагдар, Авиан Цэхэр, Калжийн Гэцэл, Дашийн Цэрэнжав, Цагаанаагын Чойжинжав, Мятавын Мулдуукаа, А.Чойдор, Хараадайн Дорж, Мухачийн Тамсагаа, Мухачийн Дэвээсан, Г.Цэгмид, Г.Загд, Алгаагын Бааст, Дэмбээн Лэгшид, Дэнзэний Дүгэрсид, Жавсаны Пүрэв, Жамбын Аюур, Санжжавын Шилэг, Соломын Заяат, Улиастын Ерөөлт, Тодын Гаадан, П.Дондог, Раашийн Хорлоо, Чимэдийн Идэш, Надмидын Чүрэм, Б. Поопроо, Б.Басан, М.Муучхай, Шилэгийн Жамба, Жамсран, Ёнгоруугийн Галиндэв нарын хүмүүс байна.<sup>11</sup>

<sup>10</sup> Онгон хилийн манаанд”.УБ.1983 он.252 дахь тал

<sup>11</sup> Т.Тулгаа торгууд нутгийн түүхт хүмүүсийн шаштир” хуудас 264-265



## **БАРУУН ХИЛИЙН ТУЛГАРАЛТАД АЛТАЙ, ҮЕНЧ СУМЫН АРД ИРГЭДИЙН ОРОЛЦОО**

Алтай сумаас цэргийн алба хаасан, буу зэвсэг сайн эзэмшдэг анчин гөрөөчин, хил орчмын газар нутгийг сайн мэддэг эрчүүдээс бүрдсэн хилийн цэрэгт туслах сайн дурын отрядыг сумын захиргаанд бүртгэн хувийн үнэмлэх олгодог байсан. Иймд отрядын гишүүдэд Алтай сумын Амарын Морх, Мишэлдэгийн Магнай, Хаадгар хэмээх Пунцагийн Намсрай, Таламжийн Бонд анчин хэмээх Раашийн Бөхчулуун, Хавчиг хэмээх Доржийн Зоноров, Гуужвайн Хоовоо Балдангийн Билэгт нарын хүмүүс байжээ. Эдгээр гишүүд үүргээ гүнээ ухамсарлан маш чадамгай биелүүлдэг байсан бөгөөд тэдний дотроос Т.Намсрай олон удаа хүнд бэрхшээлтэй тулгарч, олон удаа гадагшаа явж үүрэг гүйцэтгэж байжээ. Ялангуяа Гоминданы болон Оспаны цэргийн байрлал мэдэх, амьд хүч барих, хилийн цаад руу явж тагнуулын үүрэг 16 удаа гүйцэтгэсэн байдаг.

Үенч сумын газар нутаг дээр 1933 оноос эхлэн гаднын халдлага өрнөж байсан ба Цагаан түнгийн орчимд амьдарч байсан иргэд байнгын сонор сэрэмжтэй байж, оспаны дээрэмчид орж ирэхэд хөгшин настнууд, эхнэр, хүүхэд, мал ахуйгаа хулс зэгс рүү нууж эрчүүд нэгдэн тэмцэж, ялж, ялагдаж эд хөрөнгө, мал ахуй, үнэтэй цайтаа бүхнээ алдаж явсан өдөр цөөнгүй билээ. 1944 онд сумын иргэд нэгдэж “Ардын сайн дурын групп” байгуулж, 18 хүний морьт группийг ямагт бэлэн байх үүргээр хангаж А.Үлэмжийг ахлагчаар нь томилон ажиллуулж байсан ба эдгээр дайчид Ямаан ус, Хойд жаргалан, Цагаан түнгэ, Сүмээн цагаан, Хавтгайн нуруу Хөгшин бухын Зэгсний эхэнд, Мэргэн уулын тулгаралтад оролцож байсан байна. Хөгшин бухын Зэгсний эхэнд болсон тулгаралтад Улиаст багийн ард иргэд хүч нэмэн байлдаж, оспаны дээрэмчдийг зэгс рүү шахан оруулж дайсны ихэнхийг нь устаж, дээрэмдсэн малыг нь булаан авч эздэд нь хүлээлгэн өгч байсан. Мэргэн уулын тулгаралтад Ж.Нэхийт баатрын удирдлага дор оролцож байсан ба, тулгаралт дууссаны дараа Зах усны районд хяналт хийх үүрэг хүлээж ээлжээр харуулд гарч байхад тулгаралт дууссаны маргааш нь Оспаны нэг нөхөр уулнаас бууж ирэхэд барьж, Цонжийн суманд хүлээлгэн өгч байсан, 1944 онд Цагаан түнгийн хэсгээр орж дээрэм тонуул хийж Харуул овооны орчмоор хойш давж Хойд жаргалангийн айлуудыг дээрэмдэх зорилготой явсан дээрэмчдийг нутгийн иргэд нэгдэж Их бэлчирт тосон байлдаж мал ахуйгаа салган авч дайсанд томоохон хохирол учруулж байсан байдаг. Энэ мэтчилэн өдөр бүр шахуу болж байсан дээрэмчдийн халдлага довтолгоог хилчидтэйгээ хамтран таслан зогсоож явсан буурал түүх бидэнд домог мэт үлджээ.<sup>12</sup>

### **ГРУППИЙН ГИШҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ ОЛОЛТ АМЖИЛТ**

Тэртээ хүнд хэцүү он жилүүдэд Баян-Өлгий, Ховд аймгийн хилийн ойролцоо сумдын ардуудыг зэвсэглэсэн нь цагаа олсон чухал арга хэмжээ байсан бөгөөд

---

<sup>12</sup> Үенч сумын өндөр настан А.Үлэмж, Е.Магнай нарын дурсамжаас 2008он

зэвсэг бүхий энгийн ардууд улсын хилийн хамгаалалтын 2 дугаар бүст хил хамгаалах үүргийг гүйцэтгэх болсон билээ.

Генерал Доржийн даалгавраар Б.Дүгэр 1944 оны 3 дугаар сарын эхээр Шинжааны Давсан түнгэ гэдэг газар байрлаж байгаа Гоминданы цэргийн ангиас амьд хэл барьж ирэхээр хошууч Д.Лувсанбалдан, дэслэгч А.Намжил, холбоочин ахлагч Г.Жанчив нарын хамт Т. Амарзаяа, С.Мэндээ, Б.Дүгэр, Б. Батаа, А. Дүгэр нарын 10 гаруй хүнтэй явжээ. Тэд хил гарч Гоминданы цэргийн харуул суудаг өндөрлөгт шөнө байраа эзэлж, харуулын цэрэг ирэхээр нь барихаар бэлтгэжээ. Гэтэл өглөө үүрээс эхлэн битүү манан татаж, хүмүүс шуугилдах чимээ гарахаар нь Дүгэр гуай хүн явуулж шалгуулахад нь хятад цэргүүд тэмээтэй ирээд заг түүж байжээ. Тэднийг харуул үлдээлгүй буцахад нь манайхан араас нь дайрч ороод нэг цэрэг, хоёр винтов, нэлээд хэмжээний сум олзолж аваад буцжээ.

Мөн хавар нь Чингэл, Цагаан голд байрлаж байгаа Хятадын цэргийн ангийн байршил хөдөлгөөн, нэмэгдэл хүч ирж байгаа эсэх, амьд хэл олзолж ирэх даалгавартайгаар Б.Батаа, М.Ширнээ Ш.Хишигт, М.Түмбээ, Т.Даш, С.Мэндээ, Ц.Пагва, М.Маргаажаяа, холбоочин Жанчив нарын 15 хүнтэй явжээ.

Үүргийг гүйцэтгэхээр хятадын цэргийн ангийн ойролцоо тагнуулын үүрэг гүйцэтгэж байтал Б.Дорж генерал та нарын хянаж байгаа цэргийн ангийг манай онгоцнууд бөмбөгдөх тул тэндээс ухран гарах хүчийг устгах даалгавар өгчээ.

Мөн оны 4 дүгээр сард Шинжааны Саньтай, Жимсайр, Чонж хотоос торгууд вангийн хошууны гурван сумын айл өрхийн Монголд ирэх хүсэлтийг Засгийн газар зөвшөөрсөн тул Хятадын цэргийн ангиудыг тойруулан газарчлан хамгаалж аюулгүй нүүлгэж ирүүлэх даалгавар өгөгджээ.

Дүгэр гуай энэ үүргийг гүйцэтгэхээр группэдээ 30 гаруй хүнийг нэмж элсүүлж 70 гаруй хүнтэй явжээ. Тэд явсаар Цонж хотын наана Хулан тонгойхын худагт хүрч элсэн манхан дотор нууц газар байрлав.

Тэнд Монгол руу очих хүсэлтээ илэрхийлж байсан Баясгалангийн Очиртой уулзаж, түүгээр дамжуулан хошууны туслагч Нямаа, Түвдэн мээрэн нарт ирсэн хэргээ мэдэгдэхэд, унаа мал туранхай, ард олон нүүх бэлтгэлгүй байна. Иймд энэ удаа нүүх боломжгүй байна гэсэн хариу өгчээ. Энэ тухай генерал Доржид холбоогоор мэдэгдэж Т.Амарзаяа, А.Дүгэр, М.Түмбээ, Т.Чэткээ нарыг тусгай үүрэгтэйгээр үлдээгээд группийнхэн буцаж иржээ.

1944 оны 6 дугаар сард Казакийн бүлгүүдтэй хамтарч Ховог сайрын торгуудуудын тэмцэл хөдөлгөөнийг дэмжиж туслах зорилгоор манай талаас отрядын орлогч Т.Амарзаяа, нарийн бичгийн дарга Б.Чулуундай, намын хэсгийн ахлагч Х.Чойрог, А.Дүгэр, Т.Чэткээ, М.Маргаажаяа, С.Мэндээ, Ц.Пагва, С.Чой, М.Түмбээ, Ш.Хишигт, Б.Рааш, Г.Аюуш, А.Чулуудай, Бж Дүгэр, О.Нямдэлэг, Т.Батаа нарын 39 хүн явжээ.

Тэднийг заасан газарт очоод байтал цэргийн зөвлөх ахмад Жамъяан, ахмад Аюуш, холбоочин Б.Дамбий, Г.Жанчив нар Ховог сайрын хошуунаас манайхаас тусламж гуйхаар ирсэн төлөөлөгч мухар Мээрэн, жасын нярав Зонров, ард Пагва

нарын 22 хүнийг дагуулж ирэв. Т.Чэткээ, Пагва хоёрыг Ховог сайрын нутгийн гүн рүү тагнуулд явуулав.

1944 оны 7 дугаар сарын 10-ны үүрээр Ховог сайрын Нижээ зангийн захирсан дундаа 50 буутай 300 хүн, Тэсгэмбэйн 15, Рамазааны захирсан дундаа 30 буутай 250 хүн. Дүгэрийн отрядынхантай нийлэн Ховог сайрын Живнэ хотыг бүсэлж Ховог сайрын ван Чойжавт (Доржраашийн хатан) хошууны ард олны шаардлагыг биелүүлэхгүй бол цэрэг зэвсгийн хүчээр хошууны захиргааны эрхийг авах болно гэдэг албан шаардлага хүргүүлэхэд 7 дугаар сарын 12-нд ван Чойжавын хариу явуулсан бичгийг 2 лам авч ирэв.

Босогчдын толгойлогчдод явуулсан уг бичигт: Та нар ар Монголын оргодол Дүгэрийг дагаж ард олны амгалан тайван байдлыг алдагдуулж байгаа чинь буруу. Та нар Хятадыг яагаад ч дийлэхгүй. Иймд Дүгэрийг амьдаар нь барьж ирвэл 20000 юань, алаад толгойг нь авч ирвэл 10000 юаниар шагнаж, дуртай албан тушаалд чинь томилно гэсэн байжээ.<sup>13</sup>

Энэ нь вангийн ятгалгад орж толгойлогчдыг устгаж магадгүй гэсэн түгшүүр төрүүлж байв. 7 дугаар сарын 12-нд Вангийн хүрээнээс 80 гаруй морин цэрэг гарч баруун хойш явахад нь манай отрядынхан тосон хориглож, хятад цэргүүд нэгэн хонхор жалганд бууж, дарга нь яриа хийж байхад нь манай Аглуугийн Дүгэр морин дээрээсээ даргыг нь буудаж унагахад үймж сандарсан цэргүүд рүү манайхан гал нээж 65 цэргийн газар дээр нь устгаж бусдыг нь зугтаалгав.

Тэндээс 60 винтов, үлэмж хэмжээний сум олзолж Ховогийн босогчдыг зэвсэглэв. Мөн өдрийн 15 цагийн үед отрядаас алсын харуулд гарсан Хонгион Чойрогоос Ховог голын эх рүү 21 машин цэрэг орлоо гэсэн мэдээ авч, байрандаа хамгаалагч цөөхөн хүн үлдээгээд бусад нь Ховог голын хоёр талын толгодоор байраа эзлэн хятад цэргийг тосон байлдаж үндсэнд нь устгаж 70 винтов, 2800 сум олзолж мөн босогчдыг зэвсэглэв. Ховгийн босогчдыг Нижээ занги, Чэткээ хоёр удирдав. 7 дугаар сарын 17-ны өглөө хотын хэрмээс хоёр хүн гарч ирэхэд нь манайхан хүлээн авч уулзахад нэг нь живнэ хотын дарга, нөгөө нь дотоод яамны хэлтсийн дарга гэж өөрсдийгөө танилцуулан байлдааны ажиллагаагаа зогсоохыг хүссэний дагуу хэлэлцээр хийж Живнэ хотын захиргааг босогчдын мэдэлд шилжүүлэв.

Алсын чиглэлд гарсан харуул, тагнуулчдын мэдээгээр Живнэ хотыг хамгаалахаар Шар сүмээс хятадын 2000 цэрэг гарсныг отряд, бусад бүлгүүдтэй хамтарч хоёр хоног байлдаж, хүчийг нь сарниулан бут цохив. Мөн хятадын колоничлогчид Ховог сайрын хошууны айлуудаас 10 мал тутмаас нэг мал татварт авч, найман хэсэг газар 10000 гаруй толгой мал байсныг хошууны шинэ захиргаа хураан авч айлуудад тараан өгчээ.<sup>14</sup>

---

<sup>13</sup> Г.Хүүжий. «Хилчин сэтгүүл» №5.

<sup>14</sup> Г.Хүүжий. «Хилчин сэтгүүл» №5.

Дүгэр даргатай отрядын штаб хятад цэргийн орхиод зугтаасан хуарангуудыг эзлэн авч байрлаад Ховог сайрын хошууны нутгийг гоминданы хятадын цэргээс чөлөөлж, өгөгдсөн үүргээ биелүүлснээ Дорж генералд илтгээд нутаг буцжээ.

Дотоод явдлын яамны орлогч сайд Дүйнхэржаваас Шинжианд явж Торгууд вангийн хошууг нүүлгэж ирэх Даалгавар дахин өгөгдөв. Группийнхэн Цонж хотод ирж айлуудыг 20 хоногийн дотор нүүх бэлтгэл хангах зар тараажээ.

Товлосон хугацаанд айлууд нүүж эхлэхэд Саньтай хотын шоронд байсан лам Лүндэг нарын хэд хэдэн хүнийг суллаж авах гэж байгаад гадна хамгаалалтад байсан Агдуугийн Дүгэр, Мөнхнасангийн Сүрэн, Тангадын Даачаа нар дайсны гарт харамсалтайгаар амь үрэгджээ. Дүгэр даргатай отрядынхан Торгууд вангийн хошууны гурван сумын 270 гаруй айл өрхийг 700 гаруй ам бүл, 4000 гаруй мал хөрөнгөтэй нь Шинжаанаас нарийн зохион байгуулалттайгаар, замд нь хамгаалж, Ховд аймгийн Булган сумын нутагт эсэн мэнд нүүлгэж иржээ.

Цэргийн дээд командлал Байтаг орчмоор хил нэвтэрч ирсэн дайсны талаар зөв зохистой мэдээлэл олж авах зорилгоор Хужиртын голд байрлаж буй гоминданы цэргээс амьд хэл баривчлах байлдааны үүргийг Булганы гүйцэтгэх группэд маш богино хугацаанд гүйцэтгэх үүрэг өгөгдөв.

Байлдааны энэ яаралтай үүргийг гүйцэтгэхээр 1947 оны 5 дугаар сарын 25-нд группийн орлогч дарга Т.Амарзаяа, төлөөлөгч Ц.Уртнасан, сумангийн туслах Ж.Нэхийт, цэрэг Б.Тэгшээ, туслах группийн гишүүн Б.Бадам, Б.Батаа, БЖ.ДҮГЭР, М.Түмбэй, Ц.Дашдэлэг, Т.Чэткээ нарын бүрэлдэхүүнтэй амьд хэл баривчлах байлдааны группийг томилон Байтаг уулын Хужиртын голд байрласан хуй хуй цэргийн байрлал руу явуулав.

Энэ групп Байтаг уулын баруун урьд байрладаг Олон булгаас, Хужиртын гол хүрдэг замыг нууцаар тосож, Олон булаг дахь гоминданы цэргийн штабаас, Хужиртын голд байгаа цэргийн ангитайгаа холбоо барихаар явсан хоёр цэргийн нэгийг устгаж, нэгийг нь амьдаар нь баривчилж байлдааны үүргээ онц биелүүлээд буцаж ирэв. Амьд хэлний мэдүүлгээр дайсны тухай манай урьдах мэдээлэл зөв болох нь батлагдаж, дайсны тоо, зэвсэглэл болон бусад зүйл нэгэнт тодорхой болсон учир, хилийн мөргөлдөөний асуудлыг гүнзгийрүүлэн, лавшруулалгүй, тэднийг өөрийн хилээс хөөн гаргах төлөвлөгөөг дээд командлалаас боловсруулан хэрэгжүүлсэн билээ.

1947 оны 4 дүгээр сарын 21-нд Хужиртын аманд дайсны хүч нэмэгдүүлсэн суман цэрэг нууцаар байрласныг Ж.Нэхийт, Б.Баасанжав нар илрүүлсэн байна. Ингэж Гоминданы байнгын армийн анги тусгаар улсын нутаг дэвсгэрт хууль бусаар ирж суурьшсан хийгээд баривчлагдсан цэрэг, тагнуулын мэдээ зэргээс үзэхэд хилийн шугамын ойролцоо 200 хуйхуу, хасагаас бүрдсэн хүч Байтагбогдын Оронбулаг, Хөвийн усны хавьд 250 хүнтэй Оспаны дээрэмчид, Цонж хотод томоохон нэгтгэл байгаа нь тогтоогджээ. Иймд БНМАУ-ын Засгийн Газраас “Эх нутагт минь хууль бусаар суурьшсан дайсны цэргийн ангид 24 цагийн дотор гарахыг шаардсан **тулган шаардах** бичгийг хоёр ардаар өгүүлэх, хэрэв дурдсан хугацаанд дайсан гарахгүй бол хугацаа өнгөрмөгц урьдчилан бэлтгэсэн цэргийн хүчээр

бүслэн устгах хэрэгтэй” гэсэн шийдвэрийг Булган дахь Хязгаарын Цэргийн гүйцэтгэх группэд өгсөн байна. Үүний дагуу 6 дугаар сарын 2-ны өдөр тулган шаардах бичгийг Ховд аймгийн Булган сумын харьяат Б.Бадам, Б.Чулуундай нараар хүргүүлжээ. “Бид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахын тулд энх тайвны тэмдэг болгож, пуужингаар дохио өгч, цагаан өнгийн далбаа хийсгэн очиход дайсан хараахан гал нээсэнгүй. Бадам бид хоёр тулган шаардах бичгээ авч 400 шахам метр газар явган яваад Гоминданы даргад гардуулан өгөөд” Бид БНМАУ-ын Засгийн газрын албан тоот чухал бичиг хүргэж ирсэн хүмүүс болох тул манийг хамгаалж ирсэн манай хилчин цэргүүдийг та нар бүслэн буудах явдалгүй, харин асуудлыг эв найрамдлын журмаар шийдвэрлэх ёстой” гэж хэлжээ.<sup>15</sup>


Элч нарыг хүргээд дөхөц газраас байдлыг хянаж байсан Э.Гэрэлчулуун, Ж.Нэхийт нарын удирдсан салаа цэргийг дайсан хоёр талаас нь ороож бүслэх үед Чулуундайг морийг нь унуулан буцаахад Чулуундай ирж, Хятад цэргийн дарга надад маузер буу тулган “Чи яваад бидний өмнөх энэ толгой дээр та хоёрыг хүргэж ирсэн даргаа буу зэвсэггүйгээр дагуулж ир!” гэж намайг буцаалаа” хэмээн хэлжээ. Ингээд 5-ны өдөр хошууч генерал Б.Шагдаржавын удирдсан цэргийн яамны тусгай групп, нисэх онгоцны эскадриль хүч хавсран дайсныг цохин хилээс хөөсөн боловч байлдааны ажиллагаа амжилтгүй болов. Тодруулбал, эмх замбараагүй буудалцаж байсаар дайсны хориглолтод тулж очоод харилцан гранат шидэлцэж байсан цэргүүддээ ухрах тушаал өгч байсан салааны дарга Жанавилхан алагдаж, зэрэгцэн байлдаж байсан салааны дарга Ванчиг цэргүүдээ ухруулав. Энэ үед хилийн сумангийн дарга Б.Чойжилжав, туслах Нэхийт нарын удирдсан салаа дайсны гүнд тулалдаж байлаа. Ар талаас дэмжлэггүй, зэргэлдээ хоёр салаа нь ухарсан тул хятадын цэрэг морьдын хагасыг нь алж, хүнд байдалд орсон хэдий ч тэд газрын бартаа ашиглан бүслэлтээс гарчээ. Орой болж хилийн цаанаас Оспаны 30 гаруй хүнтэй бүлэг довтлон ирж, хажуугаас дайрахад хятадууд хий зайг ашиглан ухран зугтаасан байна. Байлдаан болсон газарт хийсэн шалгалтаас үзэхэд ард Б.Бадамыг дээрэмчид элдвээр тамлан амийг нь хороосныг хилчид олсон юм. Энэ дайралт заасан хугацаанаас хоёр хоногийн дараа эхэлсэн байлдааны ажиллагааг цэргийн хэргийн мэдлэг бага, тулалдааны дадлага туршлагагүй хүнээр удирдуулсан, элчээр, дайсны хэзээний мэдэх тагнуулч Б.Бадамыг явуулсан зэрэг алдааг зөвтгөх үндэслэл бага билээ.<sup>16</sup>

---

<sup>15</sup>. “Хилчид өгүүлж байна” УБ.1973 он.248 дахь тал.Б.Чулуундайн дурсамж

<sup>16</sup> “Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл”.УБ.1990 он.234 дэх тал

Ардын сайн дурын отрядын дайчдын байгуулсан гавьяа зүтгэлийг төр засаг өндрөөр үнэлж Б. Бадам, Э. Шилэг нарт БНМАУ-ын баатар цол олгосноос гадна



БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1944 оны 11 дүгээр сарын 14- ний өдрийн 88 дугаар тогтоолоор Отрядын дарга Б.Дүгэр, цэргийн зөвлөх ахмад Ж.Жамъяан, ард Агдуугийн Дүгэр, Т.Чэткээ нарыг байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор, Т.Амарзаяа, Б.Чулуундай, Ц.Пагва, ахлагч Г.Жанчив нарыг Алтангадас одонгоор, Бж.Дүгэр, Ш.Хишигт, О.Нямдэлэг, Б.Батаа, М.Түмбээ нарыг байлдааны медалиар шагнагдаж түүхэнд мөрөө тод үлдээсэн байна.

### Товч дүгнэлт

1. Торгуудын ард түмэн казах хятад хэл сайн мэддэг.
2. Хилийн цаана нутаглаж байсны хувьд газар орноо сайн мэддэг.
3. Их нүүдлийн үед олон тулалдаанд орж ялж ялагдаж явсан ахмадынхаа ариун туршлагаас суралцсан зэрэг нь үүрэг гүйцэтгэхэд чухал түлхэц болсон байна.
4. 1915оноос Манж Хятадын нутаг хэмээгдэж байсан Байтаг, Хавтагын нуруу Булган голын сав газрыг хамгаалан тэмцэж өнөөдрийн сайхан газар нутгаа харьд алдахгүй авч үлдэж чадсан нь Торгууд, Захчин баатарлаг түмний бахархал юмаа.
5. Ардын сайн дурын групп байгуулан мэргэжлийн үүрэг чиглэлээр хангаж, ямагт тусалж дэмжиж явсан төр засгийн удирдлага, генерал Б.Дорж, Э.Гэрэлчулуун нарын гавьяаг баруун хилийн сумын ард иргэд, үр хойч нь одоо болтол бахархан ярьж байдгийг энд хэлэх нь зөв болов уу.